

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын
2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
01/356 албан бичгийн хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТЫН ШАЛГАЛТЫН
ГАЗАРТ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН НЭГДҮГЭЭР УЛИРАЛЫН ТАЙЛАН
(2026.01.02-2026.03.25)**

2026 оны 03 дугаар сарын 27
Нэг: Шийдвэрлэлтийн талаар


Улаанбаатар хот

Байгууллагын хэмжээнд иргэдээс гаргасан, өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж хууль, зүйн үндэслэлтэй, бүрэн барагдуулж, хуулийн хугацаанд шийдвэрлэх, шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийг арилгах, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох, өргөдөл, гомдлын шалтгаан нөхцөлийг нарийвчлан судалж шийдвэрлэлтийг сайжруулах зорилго тавин ажиллаж байна.

2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт 453 өргөдөл, гомдол хүлээн авч хугацаандаа шийдвэрлэсэн 337 буюу 74.39 хувь, шийдвэрлэх шатандаа байгаа 115 буюу 25.39 хувь, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1 буюу 0.22 хувь байна.


Өргөдөл, гомдлын тоон үзүүлэлт:

График 1




➤ **Өргөдөл, гомдлын төрөл:**

График 2




➤ **Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:**

График 3




➤ **Өргөдөл, гомдлын хариу өгсөн хэлбэр**

График 4



➤ **Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх дундаж хугацаа 18 хоног 2 цаг 51 минут:**

График 5



➤ **Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад гарсан зөрчил.**

График 7



➤ **Ирсэн гомдлын агуулга**

Барилга байгуулалмжийн ашиглалт бүртгэлийн хэлтэс:

1. Барилга байгууламжийн ашиглалттай холбоотой – 5,
2. Барилга байгууламж ашиглалтад орсон эсэхтэй холбоотой – 5,
3. Барилгын ашиглалт, ус дулаан, халаалттай холбоотой – 3,
4. Бусдын газар дээр барилга байгууламж барьсан эсэхэд тодруулга авах -1,
5. Барилга байгууламжийн гадна цахилгаан улс хүлээж авсан эсэхтэй холбоотой – 1,
6. Барилга байгууламжийн цахилгаан шат ашиглалтад орсон эсэхтэй холбоотой – 28

Дотоод хяналт шинжилгээний хэлтэст:

1. Албан даалгаврын биелэлт хангуулах тухай гомдол-1,
2. Объект дээрээ ямар арга хэмжээ авсан юм бэ гэх гомдол-1,
3. Компанийн оршин суугчдаас ашиглалтын зардал нэрээр мөнгө хурааж буй үйл ажиллагаанд шалгалт хийж, арга хэмжээ авч өгнө үү гэх гомдол-1,
4. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох тухай хүсэлт-1,
5. Алба хаагч өргөдөл, гомдлыг үндэслэлгүй шийдвэрлэсэн гэх гомдол-2,
6. Алба хаагч гомдол шийдвэрлэж өгөхгүй байна гэх гомдол-7,
7. Ашиглалтын шаардлага хангахгүй байр улсын комисс хүлээж авсан гэх гомдол-1,
8. Алба хаагч албан тушаалаа урвуулан ашиглан мөнгө хураасан гэх гомдол-1

Барилгын стандарт аюулгүй байдлын хяналтын хэлтэст:

1. Барилгад өргөтгөл хийсэн, хана нураасан, өрөмдөж хаалга гаргасан, орон сууцанд цууралт, хамгаалалтгүй барилга барьсан, орц гарц хаасан гэх гомдол-60
2. Шөнийн цагаар барилга баригдаж байна гэх гомдол-18
3. Зөвшөөрөлгүй барилга, гарааш, агуулах барих, барилга нурааж газар шорооны ажил хийгээд байна гэх гомдол- 38
4. Барилгын ашиглалтын гомдол /зориулалтын бусаар ашиглаж, дуу чимээ гаргасан, хурц үнэртсэн, цахилгаан шат унасан, кран гэх мэт./-23
5. Барилгын материалын чанар муу, хагарч, сийгэх талаарх гомдол-14

6. Барилгын норм ба дүрэм зөрчсөн, хангахгүй байна, хугацаандаа ашиглалтад ороогүй барилгын ажлын явц шалгуулах тухай гэх гомдол-10
7. Улсын байцаагч иргэнээс ирүүлсэн гомдлыг эцэслэн шийдвэрлэхгүй байгаа талаар-1
8. Архитектур төлөвлөлтийн даалгавар хуурамчаар үйлдсэнийг шалгуулах тухай-1
9. Барилга хоорондын зай стандартгүй гэх гомдол-1
10. Улсын байцаагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байна гэх гомдол-1
11. Улсын комисстой холбоотой гомдол-1

Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэст:

1. Хийн тоног төхөөрөмж-2,
2. Шатахуун түгээх станцын зай хэмжээтэй холбоотой-1,
3. Цахилгаан хангамжийн ашиглалт аюулгүй ажиллагаатай холбоотой-2,
4. Авто машины техникийн бүрэн бүтэн байдлыг шалгуулах-1,
5. Агааржуулалтын сэнс нь их чимээтэй, үнэр ихтэй, чанга дуу чимээ гардаг чичиргээтэй тухай -25,
6. Цэвэр бохир усны шугам сүлжээ гэмтээсэн, тасарсан, зэвтэй ус гарсан- 1,
7. Далан суваг эвдсэн хамгаалалтын суваг зөрчсөн-2,
8. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаатай холбоотой-1
9. Цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар, үйлчилгээний тухай-6,
10. Хоолны газар, баар, рестораны үйлчилгээтэй холбоотой-1,
11. Орон сууцны конторын үйл ажиллагаатай холбоотой-2,
12. Барилга байгууламжийн дулаан дэд бүтцийн чанар аюулгүй байдал-8

Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэст:

1. Орчны аюулгүй байдал хангуулаагүй -2
2. Газрын тухай -2
3. Хүний эрхийн зөрчлийн тухай -1
4. Гүний устай холбоотой- 1
5. Барилгын хашаа нурсан гэх- 1

Хоёр: Саналын шинжтэй өргөдөл, гомдол.


Тус газарт иргэдээс ирүүлсэн 4 саналын өргөдөл бүртгэгдсэнээс аль нь ч саналын шинжтэй өргөдөл байгаагүй болно.

Гурав: Иргэдээс гомдол гаргасан шалтгаан нөхцөлийг дүгнэн үзэхэд;

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар байгууллагын хэмжээнд иргэдээс нийт 410 өргөдөл, гомдол ирүүлсэн нь өмнөх оны нэгдүгээр улирлын байдалтай харьцуулахад 9.68% хувиар өссөн ч нийт 453 өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг бүх талаас нь судлан үзэж хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг хуульд заасан хугацаанд хууль зүйн үндэслэлтэйгээр шийдвэрлэн ажилласан.

График 8

2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН НИЙТ 410 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ



Газрын хэмжээнд нийт шийдвэрлэгдсэн 410 өргөдөл, гомдлоос 211 буюу 51.46 хувийг тухайн иргэний талд шийдвэрлэж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулсан.

Мөн тус газарт хандаж ирүүлж буй өргөдөл, гомдлоос дийлэнх нь тухайн барилга, байгууламжийг улсын комисс хүлээн авахаас өмнө болон улсын комисс хүлээн авснаас хойш үүссэн иргэдийн болоод тухайн барилга барьж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын буруутай үйлдлээс үүдэлтэй өргөдөл, гомдол эзэлж байна.

Дээрх асуудлын дийлэнх нь нийслэлийн Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын эрхлэх асуудлын хүрээнд хамааралтай асуудал байх тул өргөдөл, гомдол анх бүртгэж шилжүүлэхдээ чиг үүргийг байгууллагуудад оновчтой шилжүүлэх нь тухайн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд ихээхэн хамааралтай тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дөрөв: Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад зөрчил гаргасан албан хаагчид авсан арга хэмжээ.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг болон Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу иргэний гомдлыг шийдвэрлэх явцад зөрчил гаргасан 10 албан хаагчид газрын хөдөлмөрийн дотоод журам болон газрын даргын 2025 оны А/20 дүгээр тушаалаар батлагдсан “Албан хаагчдын сахилга, дэг журам, ёс зүйн шаардлагыг хангуулах арга хэмжээний тухай” тушаалын дагуу хяналтын шар хуудас олгож дахин зөрчил гаргахгүй байх талаар заавар зөвлөмж өгч ажиллав.

Зөрчлийн бүртгэл

Д/д	Хэлтэс	Албан тушаал	Албан хаагч	Өргөдлийн дугаар	Зөрчлийн дэлгэрэнгүй	Авсан арга хэмжээ	Сануулсан огноо	Тоо
1	ДБСХХ	ЭХУАБ	З.Очирпүрэв	G260121188, G260121140	Өдөрт нь аваагүй	Шар хуудас	2026.01.27	4
2	БСАБХХ	ИТСА	Б.Энхтөр	G260116032	Өдөрт нь аваагүй	Шар хуудас	2026.01.27	5
3	ББАБХ	БАСА	Х.Хассуурь	C260106089	Явц хөтлөөгүй	Шар хуудас	2026.01.27	1
4	БСАБХХ	БТХУБ	Т.Ойдовдорж	G260205013	Явц хөтлөөгүй	Шар хуудас	2025.02.09	1
5	БСАБХХ	БТХУБ	Б.Өнөртэгш	G260210028	Явц хөтлөөгүй	Шар хуудас	2026.02.09	1
6	ДБСХХ	ЭХУАБ	З.Очирпүрэв	G260126055	Явц хөтлөөгүй	Шар хуудас	2026.03.03	1
7	БСАБХХ	БТХУАБ	З.Ганбат	O260228026	Өдөрт нь аваагүй	Шар хуудас	2026.03.03	1
8	БСАБХХ	БТХУАБ	Ц.Алтансүх	5 зөрчил	Явц хөтлөөгүй	Шар хуудас	2026.03.03	5
9	ЗСХ	ОНХА	Г.Мөнхзул		Явц хөтлөөгүй	Шар хуудас	2026.03.03	1
10	ОАБХХ	ОАБХА	А.Дэлгэрбат	G260116032	Явц хөтлөөгүй	Шар хуудас	2026.03.03	1

Тав.Тайлант хугацаанд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1 өргөдөл, гомдлын талаар:

Иргэн О.Баатарсүхийн гаргасан G260122101 дугаартай өргөдлийг БСАБХХ-ийн БТХУБ Б.Шинэжаргал нь судалж шийдвэрлэсэн бөгөөд 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдөр иргэнээс нэмэлт материал авч судлах шаардлагатай байсан тул 30 хоногоор сунгуулан 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хааж шийдвэрлэсэн боловч Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлт хариуцсан ажилтан нь шийдвэрлэлтийг буцаан тухайн өргөдөл хариуцсан албан хаагчид мэдэгдээгүйгээс үүдэлтэйгээр өргөдөл, гомдлын хуулийн хугацааг хэтрүүлсэн шийдвэрлэсэн зөрчил бүртгэгдсэн. Манай байгууллагын хувьд Аж ахуйн нэгж байгууллага болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, Газрын даргын баталсан төлөвлөгөөт хяналт шалгалт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар гадуур ихэвчлэн ажилладаг тул өргөдлийн системийг байнга шалгах боломжгүй байдаг тул дээрх зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй байна.


№ G260122101

шийдвэрлэлтийн хяналт хариуцсан ажилтан
Утас: 75751200

Хэлтэс, нэгж: Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв
Огноо: 2026-02-16 08:28


Өргөдөл, гомдлын хугацааг сунгалаа.

Тайлбар: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын 7 дугаар зүйлийн 7.3, 7.4-т заасныг тус тус үндэслэн уг өргөдөл, гомдлыг 30 хоногоор сунгав.

14  **Б.Шинэжаргал**
Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (барилга)
Утас: 70118040 #1114


Байгууллага: Хяналт шалгалтын газар
Хэлтэс, нэгж: Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс
Огноо: 2026-02-25 08:56

Шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөв. Тайлбар: Хяналт шалгалт үргэлжилж байна.

15  **Б.Шинэжаргал**
Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (барилга)
Утас: 70118040 #1114


Байгууллага: Хяналт шалгалтын газар
Хэлтэс, нэгж: Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс
Огноо: 2026-03-05 08:37

Шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөв. Тайлбар: Хяналт шалгалт үргэлжилж байна.

16  **Б.Шинэжаргал**
Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (барилга)
Утас: 70118040 #1114

Байгууллага: Хяналт шалгалтын газар
Хэлтэс, нэгж: Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс
Огноо: 2026-03-13 16:19

Шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтлөв. Тайлбар: Хяналт шалгалт үргэлжилж байна.


17  **Б.Шинэжаргал**
Барилгын техникийн хяналтын улсын байцаагч (барилга)
Утас: 70118040 #1114

Байгууллага: Хяналт шалгалтын газар
Хэлтэс, нэгж: Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс
Огноо: 2026-03-24 08:20


Өргөдөл, гомдлыг шийдвэрлэлээ.

Тайлбар: Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо зүүн хүрээ хотхоны 203 дугаар байранд фитнесийн үйл ажиллагаа эрхлээд амгалан байдал алдагдуулаад байна гэх гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд Орон сууцны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт (Нийтийн зориулалттай орон сууцны байшинд барилгын төлөвлөлт, эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын норм зөрчсөн, мөн дор дурдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно)-д хамаарахгүй байх тул үйл ажиллагааг хязгаарлах боломжгүй байна.

ТӨЛӨВ ИРГЭН БУЦААСАН ТҮҮХ (1)

 **Б.Шинэжаргал** 2026-03-23 11:33
Өргөдөл, гомдлыг шийдвэрлэлээ.

Тайлбар: Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо зүүн хүрээ хотхоны 203 дугаар байранд фитнесийн үйл ажиллагаа эрхлээд амгалан байдал алдагдуулаад байна гэх гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд Орон сууцны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт (Нийтийн зориулалттай орон сууцны байшинд барилгын төлөвлөлт, эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын норм зөрчсөн, мөн дор дурдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглоно)-д хамаарахгүй байх тул үйл ажиллагааг хязгаарлах боломжгүй байна.

 **А.Отгонжаргал** 2026-03-23 12:25
Үйлдлийг буцаалаа.

Тайлбар: Үг, үсгийн алдааг засварлаж, хаалтын үйлдлээ хийнэ үү.

Хэлтэс, нэгжийн дарга эргэн танилцах

Шийдвэрлэх Шилжүүлэх

Хэвлэх Буцаах

ТЭМДЭГЛЭЛ (0) ЗӨРЧИЛ (0)

500 -аас 0 тэмдэгт бичсэн байна.

← Энд дарж файл хавсаргана уу!

✓ Хадгалах

Зургаа.Байгууллагын зүгээс хэрэгжүүлэх, хэвшүүлэх ажил

Үүнд:

1. Хэрхэн шийдвэрлэсэн талаар гомдол гаргагчдаа мэдэгдэхгүй байгааг удаа дараа дурдсаар байгаа тул “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага 8.1.1-д “иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх” гэснийг мөрдөж онцгой анхаарч ажиллах,
2. Шийдвэрлэж буй өргөдөл гомдолд “иргэн тэмдэглэл бичлээ” цэс ажилладаг болсон байх тул албан хаагчийн шийдвэрлэлтийн байдал болон явцын тэмдэглэл тухайн гомдол гаргагчид харагдаж байгааг анхаарах,
3. Нийт албан хаагчдад албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд дагаж мөрдөх дүрэм, журмыг танилцуулан өргөдөл, гомдолд зөрчил үүсгэхгүй байх,
4. Албан хэрэг, хөтлөлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар заавар зөвлөмж арга зүйгээр цаг тухай бүрд мэдээллээр хангаж ажиллах,
5. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад үг үсгийн алдаа, үгийн сонголт, утга найруулгыг анхаарах, өргөдлийн шийдвэрлэлт үндэслэлтэй, үнэн зөв байхаар мэдээлэх,
6. Өргөдөл, гомдлын явцын тэмдэглэлийг үнэн бодитой хөтлүүлэх,
7. Өргөдөл, гомдлын утгыг харгалзан үзэж өргөдлийн хариуг албан ёсоор өгөхөөр цохолт хийх,
8. Өргөдөл, гомдлын зөрчил гаргахгүйн үүднээс гадуур хяналт шалгалтаар ажиллаж буй албан хаагчдад өргөдөл хүлээн авах, явцын тэмдэглэл хөтлөх, өргөдлийг буцаах чиглэл өгч ажиллаж байна.

ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН АЖИЛТАН



Б.МӨРӨНГУА